




03/2021

Тархаасан: 4 дүгээр сарын 15



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 3 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 2.5 хувь, өмнөх оны эцсээс 3.1 хувь, өмнөх сараас 0.6 хувиар өссөн байна.

Зураг 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.1 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.3 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн хэдий ч орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 5.3 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 11.0 хувь), тээврийн бүлгийн үнэ 5.1 хувиар буурсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 3 дугаар сард өмнөх оны эцсээс 3.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.5 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 2.8 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.1 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2021 оны 3 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2021 III	2021 III	2021 III
		2020 III	2020 XII	2021 II
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>102.5</b>	<b>103.1</b>	<b>100.6</b>
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	108.1	108.2	101.4
Согтууруулах ундаа, тамхи	4.4	102.7	100.9	100.1
Хувцас, бөс бараа, гутал	16.6	102.7	100.2	100.1
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	94.7	102.7	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	104.2	101.9	100.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	104.2	101.5	100.1
Тээвэр	14.4	94.9	100.9	100.3
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.3	100.2	100.1
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	100.7	100.1	100.0
Боловсролын үйлчилгээ	4.8	100.8	100.4	100.4
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	107.7	104.9	103.7
Бусад бараа, үйлчилгээ	5.4	104.9	101.5	100.6

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний индекс 2018 оны 3 дугаар сард 6.6 хувь, 2019 оны 3 дугаар сард 6.7 хувь, 2020 оны 3 дугаар сард 6.4 хувь гарч байсан бол 2021 оны 3 дугаар сард 2.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.9 пунктээр буурсан байна.

Хүснэгт 2. Инфляцад бараа, үйлчилгээний бүлгүүдийн үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 3 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	2018 III	2019 III	2020 III	2021 III
<b>Ерөнхий индекс</b>	<b>6.6</b>	<b>6.7</b>	<b>6.4</b>	<b>2.5</b>
Хүнсний бараа, ундаа, ус	1.5	2.1	2.7	2.2
Согтууруулах ундаа, тамхи	0.3	0.2	0.2	0.1
Хувцас, бөс бараа, гутал	0.6	1.2	1.1	0.4
Орон сууц, ус, цахилгаан, түлш	1.2	0.9	0.5	-0.5
Гэр ахуйн тавилга, бараа	0.3	0.2	0.2	0.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.4	0.4	0.1	0.2
Тээвэр	1.3	0.7	0.2	-0.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.0	0.0	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.1	0.3	0.3	0.0
Боловсролын үйлчилгээ	0.3	0.3	0.5	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	0.2	0.2	0.3	0.2
Бусад бараа, үйлчилгээ	0.4	0.2	0.3	0.3

Инфляцын түвшин 2021 оны 3 дугаар сард улсын хэмжээнд 2.5 хувь гарсны 2.2 нэгж буюу 88.0 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.


Хүснэгт 3. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 3 дугаар сард

Үзүүлэлт	2019 III		2020 III		2021 III		Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь	
<b>Ерөнхий индекс</b>	<b>6.7</b>	<b>100.0</b>	<b>6.4</b>	<b>100.0</b>	<b>2.5</b>	<b>100.0</b>	
Импортын барааны нөлөө	2.4	35.8	2.2	34.4	0.9	36.0	

бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байгаа бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлж байна.


Инфляц 2021 оны 3 дугаар сард 2.5 хувь гарсны 36.0 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 1.6 пунктээр өссөн байна.

Зураг 2. Хүнс, хүнсний бус бүлгийн үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар



Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2020 оны 3 дугаар сард 9.6 хувиар, 2021 оны 3 дугаар сард 7.4 хувиар өсөж, өсөлтийн хурдац 2.2 пунктээр, хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2020 оны 3 дугаар сард 4.9 хувиар өсөж, 2021 оны 3 дугаар сард 0.2 хувиар өсөж, өсөлтийн хурдац 4.7 пунктээр буурчээ.

Зураг 3. Бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар



Барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2020 оны 3 дугаар сард 6.4 хувиар, 2021 оны 3 дугаар сард 2.7 хувиар өсөж, өсөлтийн хурдац 3.7 пунктээр, үйлчилгээний бүлгийн үнэ 2020 оны 3 дугаар сард 6.2 хувиар, 2021 оны 3 дугаар сард 1.8 хувиар өсөж, өсөлтийн хурдац 4.4 пунктээр түс түс буурсан байна.

Хүснэгт 4. Бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс, бүсээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 3 дугаар сард

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	<b>Ерөнхий индекс</b>	<b>106.4</b>	<b>106.8</b>	<b>105.3</b>	<b>105.5</b>	<b>106.3</b>	<b>106.6</b>
2020 III	Бараа	106.4	107.0	104.0	105.8	106.4	106.5
	Үйлчилгээ	106.2	106.2	109.9	104.4	105.6	107.2
	<b>Ерөнхий индекс</b>	<b>102.5</b>	<b>102.0</b>	<b>103.5</b>	<b>102.7</b>	<b>102.9</b>	<b>103.6</b>
2021 III	Бараа	102.7	101.8	104.3	103.3	103.4	103.9
	Үйлчилгээ	101.8	102.4	100.8	100.6	100.6	102.1


Хэрэглээний үнийн индексийг бараа, үйлчилгээний бүлгээр авч үзэхэд 2021 оны 3 дугаар сард Баруун бүсэд барааны бүлгийн үнэ 4.3 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ Улаанбаатар хотод 2.4 хувиар өссөн нь хамгийн их байна.

Хүснэгт 5. Хүнс, хүнсний бус бүлгийн үнийн индекс, бүлгээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 3 дугаар сард

Огноо	Хүнс, хүнсний бус	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	<b>Ерөнхий индекс</b>	<b>106.4</b>	<b>106.8</b>	<b>105.3</b>	<b>105.5</b>	<b>106.3</b>	<b>106.6</b>
2020 III	Хүнс	109.6	110.2	107.0	108.3	111.1	107.2
	Хүнсний бус	104.9	105.2	104.7	104.4	104.3	106.4
	<b>Ерөнхий индекс</b>	<b>102.5</b>	<b>102.0</b>	<b>103.5</b>	<b>102.7</b>	<b>102.9</b>	<b>103.6</b>
2021 III	Хүнс	107.4	107.9	106.8	107.3	105.3	108.8
	Хүнсний бус	100.2	99.0	102.3	100.9	101.7	101.4

Хэрэглээний үнийн индексийг хүнс, хүнсний бус бүлгээр авч үзэхэд 2021 оны 3 дугаар сард Зүүн бүсэд хүнсний бүлгийн үнэ 8.8 хувиар, хүнсний бус бүлгийн үнэ Баруун бүсэд 2.3 хувиар өссөн нь хамгийн их байна.

Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн индекс (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, сараар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2021 оны 3 дугаар сард өмнөх оны эцсээс 15.9 хувь, өмнөх сараас 2.8 хувиар өслөө. Өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 5.5 хувь, хонины ястай махны үнэ 8.0 хувиар өссөн голлон нөлөөлжээ.

**Улаанбаатар хот:**

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2021 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.7 хувь, өмнөх оны эцсээс 3.4 хувь, өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өслөө.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 8.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 2.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 4.3 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 8.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн хэдий ч орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 9.4 хувь, тээврийн бүлгийн үнэ 5.0 хувиар буурсан байна.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 3 дугаар сард өмнөх оны эцсээс үеэс 3.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 8.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 0.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 4.2 хувь өссөн нь голлон нөлөөлжээ.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 3 дугаар сард өмнөх сараас 0.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.2 хувь, орон сууц, ус, цахилгаан түлшний бүлгийн үнэ 0.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод 2020 оны 3 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 17.7 хувь буюу 61 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 2.3 хувь буюу 8 бараа, үйлчилгээний үнэ буурч, 79.9 хувь буюу 275 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 42 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг 5. Улаанбаатар хотын хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар




Зураг 6. Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2021 оны 3 дугаар сард 14 578 төгрөгийн үнэтэй байгаа нь 2018 оны 3 дугаар сараас 57.1 хувь, 2019 оны 3 дугаар сараас 29.1 хувь, 2020 оны 3 дугаар сараас 6.0 хувиар, өмнөх оны эцсээс 16.2 хувь буюу 2027 төгрөг, өмнөх сараас 1.0 хувь буюу 143 төгрөгөөр өссөн байна.

Зураг 7. Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ 2021 оны 3 дугаар сард 12 666 төгрөгийн үнэтэй байгаа нь 2018 оны 3 дугаар сараас 63.9 хувь, 2019 оны 3 дугаар сараас 35.1 хувь, 2020 оны 3 дугаар сараас 8.6 хувиар өссөн, өмнөх оны эцсээс 13.0 хувь буюу 1 458 төгрөг, өмнөх сараас 0.5 хувь буюу 60 төгрөгөөр өссөн байна.

Зураг 8. Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр



Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай махны 1 кг дундаж үнэ 2021 оны 3 дугаар сард 10 692 төгрөгийн үнэтэй байгаа бөгөөд 2018 оны 3 дугаар сараас 63.7 хувь, 2019 оны 3 дугаар сараас 34.7 хувь, 2020 оны 3 дугаар сараас 9.5 хувиар өссөн, өмнөх оны эцсээс 24.6 хувь буюу 2 113 төгрөг, өмнөх сараас 2.2 хувь буюу 233 төгрөгөөр өссөн байна.

Зураг 9. Улаанбаатар хотод худалдаалагдаж буй нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2021 оны 3 дугаар сард 1 445 байгаа нь 2018 оны 3 дугаар сараас 16.5 хувь, 2019 оны 3 дугаар сараас 17.0 хувь, 2020 оны 3 дугаар сараас 18.9 хувиар бүүрсан бол, өмнөх оны эцсээс 0.9 хувь буюу 13 төгрөгөөр өсөж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна.


**Аймаг:**

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс бүх аймагт 1.0-6.4 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 3 дугаар сард Сэлэнгэ аймагт 1.0 хувиар өссөн нь хамгийн бага, Баянхонгор аймагт 6.4 хувиар өссөн нь хамгийн их байна.

Зураг 10. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг нийслэлээр, жил бүрийн 3 дугаар сард (өмнөх оны мөн үеэс)



Зураг 11. Аймагудад худалдаалж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ, жил бүрийн 3 дугаар сард, төгрөгөөр



Аймагудад 2021 оны 3 дугаар сард зарагдаж буй хонины ястай 1кг махны дундаж үнэ нь 8810 төгрөг болж, 2020 оны 3 дугаар сараас дунджаар 510 төгрөг, 2020 оны 12 дугаар сараас 1284 төгрөгөөр их байна.

Хонины ястай 1кг махны дундаж үнэ 2021 оны 3 дугаар сард Булган аймагт 7746 төгрөг байгаа нь хамгийн бага, Хэнтий аймагт 10014 төгрөг байгаа нь хамгийн их байна.

**Ойлголт, тодорхойлолт:**

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

**Тооцох аргачлал:**

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left( \frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left( \frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left( \frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left( \frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

$I_{ct}^L$  – тайлант үеийн хувиргасан Ласпейресийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

$P_t^i$  – i барааны тайлант үеийн үнэ

$P_o^i$  – i барааны суурь үеийн үнэ

$Q_o^i$  – i барааны суурь үеийн жин

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан. Мөн аймгийн дундаж үнийг тооцохдоо сонгогдсон 112 сумын үнийн мэдээллийг хамруулж байна.

Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн барааны үнийг сум, аймаг, дүүрэг, нийслэлээс сар бүр цуглуулж байна.

**Эх үүсвэр:** УСХ, Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

**Ангилал, код:** ХЗХБҮА

**Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>



**Дараагийн мэдээ тархаах хуваарь:** 2021 оны ... дугаар сарын ...

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга Э.Эрдэнэсан  
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын статистикч  
Д.Батсүх,  
Т.Жигжидсүрэн  
Утас : (976-51)-261561



medeelel statistic



@statistic\_mn



information@nso.mn



Лавлах утас: 1900-1212